

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ЗАХИРАЛ Т. ГАНБОЛДЫН ТАВИХ ИЛТГЭЛ

Эрхэмсэг хатагтай, ноёдоо. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Гангийн үйлдвэрлэлийн дэлхий зах зээл, Монгол улсын дотоод зах зээл, Монгол улсын дотоод зах зээлийн хэрэгцээ, эрчим хүч, түүхий эдийн баазыг түшиглэн Дархан-Сэлэнгийн бүс нутагт орших төмрийн хүдэр, нүүрсний ордуудыг ашиглаж, “Уул уурхай-металлургийн үйлдвэр” цогцолборыг барьж байгуулах нь тус улсын эдийн засаг, экспортын чадамжийг нэмэгдүүлэх түүнчлэн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй хангах стратегийн чухал ач холбогдолтой юм.

Дархан-Сэлэнгийн бүс нутагт нийтдээ 367,9 сая тн төмрийн хүдрийн нөөц байгаагаас Төмөртэйн орд 229,8 сая тн, Баянголын орд 110,1 сая тн, Төмөртолгойн орд 25,0 сая тн-ын нөөцтэй юм.

Эдгээр ордуудаас нарийвчилсан хайгуул хийгдсэн Төмөртэй, Төмөртолгойн ордод хөрөнгө оруулан, хамтран ашиглах талаар Та бүгдээс санал сонсохыг хүсч энэхүү танилцуулгыг хийж байна.

Төмөртэйн хүдрийн орд нь Дархан хотоос 130 км, олон улсын авто замаас 90 км, Дулаанхааны төмөр замаас /УБ-Москва-Бээжин/ 95 км зайтай дэд бүтэц сайн хөгжсөн районд уул техникийн тааламжтай нөхцөлд оршдог орд юм. Энэхүү орд нь хүдрийн 3 биетээс тогтох бөгөөд хорт хольц болох хүхэр, фосфорын хэмжээ харьцангуй бага учир шууд ангижруулалтанд тэнцэх талаар лабораторийн туршилт дүгнэлт гарсан болно. Гадаад дотоодын лабораториудад хийлгэсэн шинжилгээгээр Төмөртэйн ордын хүдэр дэх төмөр /Fe/ 54-68 %, хүхэр 0,1-0,4 % , фосфор 0,04-0,06 % байна.

Төмөртолгойн орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Дархан хотоос зүүн урагш 30 км зайд байрлана. Уг орд нь хатуу хучилттай замаас 15-17 км, Улаанбаатар-Сүхбаатарын төмөр замаас 20-25 км-т, Дархан хотоос Шарын голын нүүрсний уурхай уруу явсан төмөр замаас 8-10 км зайд оршдог.

Хүдрийн төвийн болон зүүн биетүүд хөрснөөс 1-15 метрийн гүнд байрлах тул ил аргаар олборлолт явуулна.

Дээрхи ордуудыг түшиглэн уул уурхай-металлургийн үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эхний үе шатанд Төмөртолгой, Төмөртэйн төмрийн хүдрийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийг байгуулна. Энэ төслийг хэрэгжүүлэхэд 250 орчим сая ам. долларын урьдчилсан хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Дээрхи уурхай, үйлдвэрийг байгуулсанаар жилдээ 3-5 сая тн хүдэр олборлож, бөөмцөг үйлдвэрлэн, металлургийн 2-р ээлжийн үйлдвэрийг ашиглалтанд орох хүртэлхи хугацаанд экспортод гаргана.

Хоёрдугаар үе шатанд Гангийн үйлдвэрийн цогцолбор барьж байгуулна. Жилдээ 2 хүртэл сая тн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Монгол улсын гангийн дотоод зах зээлийн жилийн хэрэгцээг бүрэн хангаж, үлдсэнийг нь экспортод гаргана. Хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум орчим ам. доллар болно.

Энэхүү Дархан-Сэлэнгийн бүс нутагт орших Төмөртэй, Төмөртолгойн ордын хүдрийг олборлон баяжуулж, уул уурхай-төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулсанаар Монгол улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулна.

Дээрхи төслүүдийг хэрэгжүүлсэнээр дараахи зорилтуудыг шийдвэрлэнэ. Үүнд:

1. Төмрийн хүдрийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.
2. Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн түүхий эдийн найдвэртэй эх үүсвэрийг бий болгоно.
3. Төмөрлөгийн үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл, техник, зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
4. Ил уурхай, баяжуулах үйлдвэр, ширэмний үйлдвэр шинээр байгуулж, гадаад зах зээлд шинэ бүтээгдэхүүн экспортолж, хөрөнгийн эх үүсвэртэй болно.

Та бүхнийг энэ асуудалд анхаарлаа хандуулан, ашигтай, ирээдүйтэй энэ бизнест хөрөнгө оруулж, хамтран ажиллах хувилбарыг судалж үзнэ үү гэж хүсэж байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА